

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2025/010/НА-СТА-ТЗШ

Цахим хуудас: www.audit.mn Мөрөн сум 2025 он	Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар Утас: 88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Давааням Утас: 88095436 Цахим хаяг: Davaanyamb@audit.gov.mn Аудитор: Г.Ичинхорлоо Утас: 88688168 Цахим хаяг: Ichinkhorloog@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.20 № 1/84
танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Үндсэн хөрөнгө данс өмнөх оноос 74,751.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 202,954.7 мянган төгрөгийн үнэ төлбөргүй шилжиж ирсэн хөрөнгийг бүртгэж, тайланд тусгасан байна. Тайлант оны элэгдлийн зардал 148,884.2 мянган төгрөг байна.

Аудитын гол асуудал

Аудитаар нийт 25,817.8 мянган төгрөгийн 8 алдаа¹, зөрчил илэрснээс аудитын явцад 22,499.9 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 2,894.3 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж хүргүүлж, 423.6 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, өмнөх оны аудитаар төлбөрийн акт тогтоосон зөрчлийг давтан гаргасан тул сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлагыг Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч нарт хүргүүлсэн.

Бусад асуудлын хэсэг

Тус газар нь тайлант онд “Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон ЗДТГ-ын хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь засаг даргад туслах чиг үүргийг хэрэгжүүлнэ.” Гэсэн зорилгын хүрээнд 7 зорилт, 72 ажил, арга хэмжээг төлөвлөн 91.4 хувийн биелэлттэй ажилласан гэж тайлагнасан байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	122,244,098.82	220,144,612.09
34	УРЬДЧИЛГАА	00.00	2,050,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	00.00	2,050,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	122,244,098.82	218,094,612.09
351	Түүхий эд материал	6,900,000.00	3,566,666.67
35110	Тусгай зориулалттай материал	6,900,000.00	3,566,666.67
354	Хангамжийн материал	99,224,098.82	210,662,945.42
35410	Бичиг хэргийн материал	1,312,470.00	4,503,910.00
35420	Аж ахуйн материал	79,259,181.83	151,560,415.08
35430	Сэлбэг хэрэгсэл	25,000.00	25,000.00
35440	Түлш, шатах тослох материал	10,899,000.00	29,344,140.02
35450	Барилгын засварын материал	731,700.00	927,200.00
35470	Бусад хангамжийн материал	6,996,746.99	24,302,280.32
35600	Мал амьтад	16,120,000.00	3,865,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,695,091,022.19	1,769,842,706.86
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,695,091,022.19	1,769,842,706.86
392	Биет хөрөнгө	1,297,739,021.95	1,372,663,956.50
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,204,865,732.00	1,344,422,332.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-294,666,165.81	-327,986,883.03
39203	Авто-тээврийн хэрэгсэл	170,618,556.55	175,071,668.55
39204	Хуримтлагдсан элэгдэл	-100,448,512.09	-111,628,971.04
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	239,678,216.28	233,872,675.28
39206	Хуримтлагдсан элэгдэл	-129,968,184.73	-131,785,565.44
39208	Хуримтлагдсан элэгдэл	-15,921,861.95	-17,005,115.56
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	7,500,000.00	7,500,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	259,907,454.00	259,907,454.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-70,828,876.30	-94,913,126.26
393	Биет бус хөрөнгө	397,352,000.24	397,178,750.36
39301	Програм хангамж	2,460,000.00	1,897,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,433,999.76	-1,044,749.64
39303	Бусад биет бус хөрөнгө	396,326,000.00	396,326,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,817,335,121.01	1,989,987,318.95
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,817,335,121.01	1,989,987,318.95
51	Засгийн газрын хувь оролцоо	1,817,335,121.01	1,989,987,318.95
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,455,184,342.39	1,455,184,342.39
51101	Өмч: - төрийн	1,455,184,342.39	1,455,184,342.39
512	Хуримтлагдсан үр дүн	44,203,648.28	216,855,846.22
51210	Өмнөх үеийн үр дүн	44,203,648.28	46,578,635.28
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	170,277,210.94
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	317,947,130.34	317,947,130.34
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,817,335,121.01	1,989,987,318.95

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	810,716,666.28	1,348,304,146.38
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	117,069,619.28	217,473,973.38
120	Нийтлэг татварын бус орлого	117,069,619.28	217,473,973.38
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	693,647,047.00	1,130,830,173.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,546,247.00	55,529,773.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,933,595.00	55,529,773.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	612,652.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	673,100,800.00	1,075,300,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	673,100,800.00	1,075,300,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	866,113,896.69	1,165,771,935.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	865,713,896.69	1,165,771,935.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	800,920,475.58	1,020,072,187.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	412,757,006.72	634,886,155.15
210101	Үндсэн цалин	286,383,179.12	417,819,500.17
210102	Нэмэгдэл	108,916,665.39	202,061,454.98
210104	Урамшуулал	17,457,162.21	15,005,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,564,089.43	78,074,903.31
210201	Тэтгэврийн даатгал	27,839,736.14	53,674,400.21
210202	Тэтгэмжийн даатгал	3,812,107.29	5,739,559.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,912,632.22	3,616,050.70
210204	Ажилгүйдлийн даатгал	762,421.53	3,008,979.03
210205	Эрүүл мэндийн даатгал	7,237,192.25	12,035,914.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,259,343.77	30,574,313.50
210301	Гэрэл, цахилгаан	6,545,793.77	7,524,579.50
210302	Түлш, халаалт	18,713,550.00	23,049,734.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,786,333.80	38,589,375.48
210401	Бичиг хэрэг	8,089,216.00	3,023,160.00
210402	Тээвэр, шатахуун	22,972,555.80	28,464,315.48
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,790,000.00	3,616,900.00
210404	Ном, хэвлэл	420,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,514,562.00	3,485,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,692,900.00	12,843,320.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	8,500.00
210604	Урсгал засвар	9,692,900.00	12,834,820.00
2107	Томилолт, зочны зардал	2,480,000.00	3,124,031.00
210701	Гадаад албан томилолт	00.00	124,031.00
210702	Дотоод албан томилолт	2,480,000.00	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	107,010,519.00	65,105,847.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	105,868,169.00	62,593,939.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	1,209,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	168,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	235,000.00	84,008.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	307,350.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	600,000.00	500,000.00
210807	Газрын төлбөр	00.00	550,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	162,370,282.86	156,874,242.46
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,312,600.00	7,830,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,000.00	160,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	158,037,682.86	148,884,242.46
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,793,421.11	145,699,747.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,460,000.00	57,453,548.00

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	6,765,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,460,000.00	50,688,548.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	62,333,421.11	88,246,199.54
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	62,333,421.11	88,246,199.54
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	400,000.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	400,000.00	00.00
223001	Бусад хөрөнгө	400,000.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-55,397,230.41	182,532,210.94
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,000,000.12	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,000,000.12	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-2,000,000.12	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-57,397,230.53	182,532,210.94

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	753,139,776.00	1,130,830,173.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	753,139,776.00	1,130,830,173.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	80,038,976.00	55,529,773.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	59,492,729.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,933,595.00	55,529,773.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	612,652.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	673,100,800.00	1,075,300,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	673,100,800.00	1,075,300,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	737,813,876.00	1,102,065,423.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	737,813,876.00	1,102,065,423.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	672,920,454.89	953,672,875.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	405,538,933.47	634,616,879.42
210101	Үндсэн цалин	276,534,498.34	403,550,062.95
210102	Нэмэгдэл	118,121,428.54	217,917,759.17
210104	Урамшуулал	10,883,006.59	13,149,057.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,932,956.05	78,344,179.04
210201	Тэтгэврийн даатгал	30,991,070.01	53,331,374.58
210202	Тэтгэмжийн даатгал	5,700,765.59	6,521,623.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,738,637.22	3,406,996.13
210204	Ажилгүйдлийн даатгал	1,416,507.93	3,048,270.79
210205	Эрүүл мэндийн даатгал	9,085,975.30	12,035,914.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,059,793.77	36,868,719.50
210301	Гэрэл, цахилгаан	6,545,793.77	7,524,579.50
210302	Түлш, халаалт	27,514,000.00	29,344,140.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,536,732.10	34,685,223.00
210401	Бичиг хэрэг	5,000,000.00	5,000,000.00

210402	Тээвэр, шатахуун	17,040,032.10	21,972,523.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,790,000.00	3,712,900.00
210404	Ном, хэвлэл	210,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,496,700.00	3,999,800.00
2105	Нормативт зардал	900,000.00	980,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	900,000.00	980,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,853,200.00	26,846,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,500,000.00	2,693,900.00
210602	Тавилга	00.00	1,200,000.00
210604	Урсгал засвар	9,353,200.00	22,952,800.00
2107	Томилолт, зочны зардал	2,480,000.00	3,000,000.00
210702	Дотоод албан томилолт	2,480,000.00	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	126,881,653.50	76,707,574.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	125,739,303.50	74,195,666.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	1,209,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	168,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	235,000.00	84,008.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	307,350.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	600,000.00	500,000.00
210807	Газрын төлбөр	00.00	550,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,737,186.00	61,623,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,300,000.00	61,463,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	437,186.00	160,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,893,421.11	148,392,547.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,560,000.00	60,146,348.60
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	26,253,348.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	6,765,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,560,000.00	27,128,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	62,333,421.11	88,246,199.54
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	62,333,421.11	88,246,199.54
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	15,325,900.00	28,764,750.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	15,325,900.00	28,764,750.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,325,900.00	28,764,750.00
2200	Дотоод эх үүсвэрээр	15,325,900.00	28,764,750.00
223001	Бусад хөрөнгө	6,928,900.00	28,764,750.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,397,000.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-15,325,900.00	-28,764,750.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-

10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
----	---	---	---

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгөлөмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Зүүллэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх Үлдэгдэл	1,455,184,342.39	317,947,130.34	101,200,878.81	1,874,332,351.54
C03	Дахин илэрхийлсэн Үлдэгдэл	1,455,184,342.39	317,947,130.34	101,200,878.81	1,874,332,351.54
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-57,397,230.53	-57,397,230.53
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх Үлдэгдэл	1,455,184,342.39	317,947,130.34	44,203,648.28	1,817,335,121.01
D01	2023 оны 12-р сарын 31-нээрх Үлдэгдэл	1,455,184,342.39	317,947,130.34	44,203,648.28	1,817,335,121.01
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн Үлдэгдэл	1,455,184,342.39	317,947,130.34	44,203,648.28	1,817,335,121.01
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	193,262,210.94	193,262,210.94
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх Үлдэгдэл	1,455,184,342.39	317,947,130.34	237,465,859.22	2,010,597,331.95

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,041,899,500.0	958,289,450.5	83,610,049.5	92.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,041,899,500.0	958,289,450.5	83,610,049.5	92.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,015,006,000.0	931,836,102.5	83,169,897.5	91.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	681,907,600.0	634,616,879.4	47,290,720.6	93.1
210101	Үндсэн цалин	394,336,100.0	403,550,063.0	-9,213,962.9	102.3
210102	Нэмэгдэл	287,571,500.0	217,917,759.2	69,653,740.8	75.8
210104	Урамшуулал	00.0	13,149,057.3	-13,149,057.3	0.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,430,300.0	78,344,179.0	7,086,121.0	91.7
210201	Тэтгэврийн даатгал	58,764,600.0	53,331,374.6	5,433,225.4	90.8
210202	Тэтгэмжийн даатгал	6,666,400.0	6,521,623.4	144,776.6	97.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,333,200.0	3,406,996.1	-73,796.1	102.2
210204	Ажилгүйдлийн даатгал	3,333,200.0	3,048,270.8	284,929.2	91.5
210205	Эрүүл мэндийн даатгал	13,332,900.0	12,035,914.2	1,296,985.8	90.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,900,000.0	36,868,719.5	31,280.5	99.9
210301	Гэрэл, цахилгаан	7,000,000.0	7,524,579.5	-524,579.5	107.5
210302	Түлш, халаалт	29,900,000.0	29,344,140.0	555,860.0	98.1
2104	Хангамж, бараа материалын зардал	35,200,000.0	26,712,700.0	8,487,300.0	75.9
210401	Бичиг хэрэг	5,000,000.0	5,000,000.0	00.0	100.0
210402	Тээвэр, шатахуун	14,000,000.0	14,000,000.0	00.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,500,000.0	3,712,900.0	2,787,100.0	57.1
210404	Ном, хэвлэл	200,000.0	00.0	200,000.0	00.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,500,000.0	00.0	5,500,000.0	00.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,000,000.0	3,999,800.0	200.0	100.0
2105	Нормативт зардал	1,000,000.0	980,000.0	20,000.0	98.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.0	980,000.0	20,000.0	98.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,993,000.0	26,846,700.0	1,146,300.0	95.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,700,000.0	2,693,900.0	6,100.0	99.8
210602	Тавилга	00.0	1,200,000.0	-1,200,000.0	#DIV/0!
210604	Урсгал засвар	25,293,000.0	22,952,800.0	2,340,200.0	90.7
2107	Томилолт, зочны зардал	3,000,000.0	3,000,000.0	00.0	100.0
210702	Дотоод албан томилолт	3,000,000.0	3,000,000.0	00.0	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	81,915,100.0	62,843,324.5	19,071,775.5	76.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	78,555,500.0	60,331,416.5	18,224,083.5	76.8

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,209,600.0	1,209,600.0	00.0	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.0	168,300.0	31,700.0	84.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.0	84,008.0	315,992.0	21.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	400,000.0	00.0	400,000.0	00.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	600,000.0	500,000.0	100,000.0	83.3
210807	Газрын төлбөр	550,000.0	550,000.0	00.0	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61,660,000.0	61,623,600.0	36,400.0	99.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	61,500,000.0	61,463,600.0	36,400.0	99.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	160,000.0	160,000.0	00.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,893,500.0	26,453,348.0	440,152.0	98.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,893,500.0	26,453,348.0	440,152.0	98.4
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,280,400.0	26,253,348.0	27,052.0	99.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	613,100.0	200,000.0	413,100.0	32.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	33,400,900.0	28,764,750.0	4,636,150.0	86.1
2200	Дотоод эх үүсвэрээр	33,400,900.0	28,764,750.0	4,636,150.0	86.1
223001	Бусад хөрөнгө	33,400,900.0	28,764,750.0	4,636,150.0	86.1
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,075,300,400.0	987,054,200.5	88,246,199.5	91.8
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,075,300,400.0	987,054,200.5	88,246,199.5	91.8
132001	Орон нутгийн төсвөөс	1,075,300,400.0	987,054,200.5	88,246,199.5	91.8
120004 4	Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		360,000.00	-360,000.00	00.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.00	25.00	00.00	100.0
620001	Удирдах ажилтан	03.00	03.00	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00	00.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00	00.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	55,529,773.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	55,529,773.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21,836,773.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,972,523.00
210402	Тээвэр, шатахуун	7,972,523.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,864,250.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,864,250.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,693,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,693,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	6,765,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	26,928,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	55,529,773.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	55,529,773.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	55,529,773.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)-(II)-(I)	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 22,499.9 мянган төгрөгийн 3 алдаа¹ илэрснээс аудитын явцад 22,499.9 мянган төгрөгийн 3 алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

1. Үр дүнгийн тайлан дахь үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын дүн бараа материалын тодруулга, үндсэн хөрөнгийн тодруулга тайлан дахь үнэ төлбөргүй авсан дүнтэй зөрүүтэй байна. НБББББ-ийн 5.3 Бараа материал, 5.4 Үндсэн хөрөнгийн ангилалд нийцээгүй, Ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байна. *Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад 7,345.0 мянган төгрөгөөр залруулсан*
2. Авто тээврийн хэрэгсэл дансны хуримтлагдсан элэгдлийг дахин тооцоолоход 2,374.9 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. НБББББ-ийн 5.4 Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох аргыг баримтлаагүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна. *Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад 2,374.9 мянган төгрөгөөр залруулсан*
3. Зам засварт зарцуулсан 30тн цемент, ахмадын баярт зориулан авсан 150ш цүнхний зарцуулалтыг бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 14 дүгээр зүйлийн 14.4.1-д "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.6-д "бүх зардал" гэж заасанд нийцэхгүй, Тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байна. *Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад 12,780.0 мянган төгрөгөөр залруулсан*

Аудитаар 2,894.3 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж хүргүүлж, 423.6 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, өмнөх оны аудитаар төлбөрийн акт тогтоосон зөрчлийг давтан гаргасан тул сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлагыг Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч нарт хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн зөрчил нь тогтоосон материаллаг байдлаас хэтрээгүй тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

Төсвийн хөрөнгөөр 423.6 мянган төгрөгийн согтууруулах ундаа бэлтгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл: Хэмнэлтийн бусад арга хэмжээ: 15.1.7-д "байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах" гэж заасныг тус тус зөрчсөн, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй тул төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

Тус газар нь өмнөх оны аудитаар согтууруулах ундаа бэлтгэсэн зөрчилд төлбөрийн акт тогтоолгосон бөгөөд тайлант онд зөрчлийг давтан гаргаж, нотлох баримтыг хуурамчаар үйлдэж, бүртгэлд тусган, санхүүжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх," гэж заасныг тус тус зөрчсөн, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөв захирагчид сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлагыг ТТЗ-д хүргүүлсэн.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын ерөнхий журналаас 4-р улирлын ажил гүйлгээг түүвэрлэн шалгахад бараа материалын зарцуулалт хийхдээ анхан шатны баримтыг хангалттай хэмжээнд бүрдүүлээгүй, төсвийн хөрөнгөөр хийгдсэн ажлын тайлан мэдээ хангалтгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ санхүүжүүлэхийг хориглоно" гэж заасныг зөрчсөн, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид хүчин төгөлдөр анхан шатны баримтаар баталгаажсан ажил гүйлгээг санхүүжүүлж, бүртгэлд тусгаж байх. Төсвөөс зарцуулсан хөрөнгийн тайлан мэдээг бэлтгүүлж, нотлох баримтаар хавсаргаж байх. Харилцагч байгууллагын кассын системээс хэвлэгдэн гарч байгаа бар код бүхий и-баримтыг анхан шатны баримтад хавсаргаж байх.

Илрүүлэлт: Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ нь ахмадын сан байгуулаагүй, жилийн төсөвтөө төлөвлөж батлуулаагүй байна. Энэ нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална" гэж заасанд нийцэхгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ахмад настны тухай хуульд заасны дагуу Ахмадын сан байгуулж ажиллах.

2. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал:

Илрүүлэлт: Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ-ын дотоод хяналтын нэгж нь тайлант онд хяналт шалгалт хийгээгүй байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн эгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 3 дугаар зүйлийн 3.7.6-д "хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх" гэж заасанд нийцээгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн эгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам" хэрэгжилтийг хангаж ажиллах

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, тодруулгын дүнтэй зөрүүтэй	1	7,345.0			1	7,345.0	1	7,345.0		
Хуримтлагдсан элэгдлийг зөрүүтэй тооцоолсон	1	2,374.9			1	2,374.9	1	2,374.9		
Бараа материалын зарцуулалтыг бүртгээгүй	1	12,780.0			1	12,780.0	1	12,780.0		
Дүн	3	22,499.9			3	22,499.9	3	22,499.9		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дотоод хяналт хангалтгүй	1	-					1	-				
Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй	1	2,894.3					1	2,894.3				
Ахмадын сан байгуулаагүй	1	-					1	-				
Зориулалт бус зарцуулалт	1	423.6	1	423.6								
Зөрчил давтан гаргасан	1	-							1	1		
Дүн	5	3,317.9	1	423.6			3	2,894.3	1	1		